



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн  
багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: YAG-CAГ/2015/29/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот  
2015 оны 4 дүгээр сар



# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

## АГУУЛГА

YAG-ын Санхүүгийн аудитын  
газрын дарга,  
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа  
Утас: 261663  
Цахим хаяг:  
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Л.Одгэрэл  
Утас: 260512  
Цахим хаяг:  
odgerell@audit.gov.mn

Шинжээч: Б.Энхжин  
Утас: 261628  
Цахим хаяг:  
enkhjinb@audit.gov.mn

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр  
Бага тойруу 3  
Улаанбаатар-15160  
Монгол Улс

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

2015 оны 4 дүгээр сар

## АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл  
Байгууллагын хууль, эрх зүйн орчин  
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа  
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй,  
хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон  
нарийвчилсан горим, түүний үр дүн  
Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл,  
тайлбар  
Дотоод хяналт  
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний  
талаарх тайлбар  
Шилэн дансны мэдээлэл  
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар  
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой  
бол) тайлбар  
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг  
шийдвэрлэсэн талаар  
Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын  
тайлбар  
Анхаарал татахуйц бусад чухал асуудал  
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд  
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн  
зөрчлийн нэгтгэл  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Зөвлөмж  
Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх  
дүгнэлт

## МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Аудит хийсэн санхүүгийн тайлан  
Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл**

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2015/29/СТА-ТЕЗ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 17-ноос 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын орон нутгийн аудитын албаны шинжээч Б.Энхжин хэрэгжүүлэв.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланд 2015 оны 3 дугаар сарын 10-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 17-ноос 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуульд заасан цаглабарын хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагад гардуулна.

## **Байгууллагын хууль, эрх зүйн орчин**

СЗХороонд дараах хууль эрх зүйн актууд мөрдөгдөж байна. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль
- Хоршооны тухай хууль
- Даатгалын тухай хууль
- Компанийн тухай хууль

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Валютын зохицуулалтын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- МУ-ын Их Хурлын 45 дугаар тогтоол “Дүрэм батлах тухай”
- МУ-ын ИХ-ын 56 дугаар тогтоол “Журам батлах тухай”
- СЗХ-ны нууц хадгалах, хамгаалах тухай журам
- Хөдөлмөрийн дотоод журам

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**

Байгууллага нь дараах үндсэн зорилготой. Үүнд:

Монгол Улсын санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, тогтвортой хөгжлийг бэхжүүлэх, санхүүгийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг бий болгох, харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хадгаламж эзэмшигчдийн эрхийг хамгаалах, олон нийтийг сургах, санхүүгийн зах зээлийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулах зорилготой. Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй ажиллаж байна.

### **Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад СЗХ нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2011 оны 5 дугаар сард Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар 176 дугаар тогтоолоор батлуулан мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

СЗХ-ны үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

СЗХ-ны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Imerald” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

### **Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгов. Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 1337.2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь буюу 26.7 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

### **Дотоод хяналт**

СЗХ-ны дотоод хяналтыг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын тогтолцоог хэвийн гэж үзэв.

### **Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар**

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2014 онд урсгал төсөв 2516.3 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд үүнээс 2434.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

### **Шилэн дансны мэдээлэл**

Монгол улсын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд хангуулан ажиллах зорилгоор тус яамны цахим хуудсанд “Шилэн данс”-ны цахим хуудсыг нээн ажиллах, зайлшгүй байх мэдээлэл, цэсний жагсаалтыг гарган тогтмол байршуулан ажиллаж байна.

### **Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлүүдийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрт нарийвчилсан горим, сорил 6-г гүйцэтгэв.

### **Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар**

СЗХ-ны даргын төсвийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний

мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

### **Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар**

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланд дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

1. СЗХ-ны 2014 оны санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийг 1337.2 сая төгрөгөөр, бараа материалыг 48.1 сая төгрөгөөр нийт 1385.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материал бүртгэсэн боловч үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллого хийгдээгүй байна.

Шийдвэрлэсэн: НББ-ийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 –т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” хөрөнгийг тоолно гэсэн заалттай нийцэхгүй байна гэж үзэн албан шаардлага өгөв.

2. Санхүүгийн байдлын тайлан бараа материалын тодруулгын тайланд нийт бараа материалын дүн 48.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан боловч бараа материалын нэр төрлөөрөө энэхүү хоёр тайланд зөрүүтэй тайлагнагдсан байна. Тухайлбал, санхүүгийн байдлын тайланд 40.7 сая төгрөгийн бичиг хэргийн материалын үлдэгдэл тайлагнагдсан байхад бараа материалын тодруулга тайланд тайлагнагдаагүй, санхүүгийн байдлын тайланд сэлбэг хэрэгсэлийн үлдэгдэлгүй тайлагнагдсан байхад бараа материалын тодруулга тайланд 3.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан, санхүүгийн байдлын тайланд 5.5 сая төгрөгийн түлш шатах тослох материалын үлдэгдэл байхад бараа материалын тодруулга тайланд -48.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Шийдвэрлэсэн: НББ-ийн программд тайлан тодрууллагуудыг Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу тайлагнагдаж байхаар зохих засвар өөрчлөлтүүдийг хийхээр зөвлөмж өгөв.

3. Аудитын явцад Бараа материалын үлдэгдлийг түүвэрлэн тулгахад бараа материалын ангилалыг дансны нэгдсэн жагсаалт болон УСНББОУС-12 –ыг мөрдөөгүйн улмаас санхүүгийн тайлангийн бараа материалын ангилал буруу хийгдсэн байна.

Шийдвэрлэсэн: УСНББОУС-12-ын дагуу бараа материалыг ангилан бүртгэхээр зөвлөмж өгөв.

### **Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар**

Залруулагдах боломжгүй алдаа байхгүй.

### **Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

### **Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

2015 оны явцын аудитаар бараа материалыг нэр төрлөөр нь ангилан УСНББОУС-ын дагуу бүртгэсэн эсэхийг шалгах.

### **Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1385.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгөв.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж 7 зөвлөмж өгсөн нь 100 хувийн биелэлттэй байна.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГЫН ТӨСВИЙН  
БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН**

**Менежментийн захидал**

**Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:**

**Асуудал 1**

Санхүүгийн тайлагналын талаар

**Асуудал 2**

Бараа материалын талаар

## **Менежментийн захидал**

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Санхүүгийн зохицуулах хорооны даргад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: Санхүүгийн тайлагнал****Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Санхүүгийн байдлын тайлан бараа материалын тодруулгын тайланд нийт бараа материалын дүн 48.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан боловч бараа материалын нэр төрлөөрөө энэхүү хоёр тайланд зөрүүтэй тайлагнагдсан байна. Тухайлбал, санхүүгийн байдлын тайланд 40.7 сая төгрөгийн бичиг хэргийн материалын үлдэгдэл тайлагнагдсан байхад бараа материалын тодруулга тайланд тайлагнагдаагүй, санхүүгийн байдлын тайланд сэлбэг хэрэгсэлийн үлдэгдэлгүй тайлагнагдсан байхад бараа материалын тодруулга тайланд 3.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан, санхүүгийн байдлын тайланд 5.5 сая төгрөгийн түлш шатах тослох материалын үлдэгдэл байхад бараа материалын тодруулга тайланд -48.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

НББ-ийн программд тайлан тодрууллагуудыг Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу тайлагнагдаж байхаар зохих засвар өөрчлөлтүүдийг хийх.

Зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 08 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэх.

**Эрсдэлүүд**

НББ зөрүүтэй тайлагнагдах;

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

|                                  |                                  |
|----------------------------------|----------------------------------|
| <b>Асуудал 2:</b> Бараа материал | <b>Тэргүүлэх ач холбогдол №1</b> |
|----------------------------------|----------------------------------|

#### **ҮАГ-ын ажиглалт**

Аудитын явцад Бараа материалын үлдэгдлийг түүвэрлэн тулгахад бараа материалын ангилалыг дансны нэгдсэн жагсаалт болон УСНББОУС-12 –ыг мөрдөөгүйн улмаас санхүүгийн тайлангийн бараа материалын ангилал буруу хийгдсэн байна.

#### **ҮАГ-ын зөвлөмж**

УСНББОУС-12-ын дагуу бараа материалыг ангилан бүртгэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 08 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэх.

#### **Эрсдэлүүд**

Бараа материал дутагдах;

#### **Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

Г САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА З.НАРАНТУЯА  
ТАНАА

2015.04.24 № 489  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

### ***Зөрчилгүй санал дүгнэлт***

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Санхүүгийн аудитын газар-А4 бланк

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ                                                              | ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ        | ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ         |
|-----------------------------------------------------------------------|-----------------------|-------------------------|
| МӨНГӨН ХӨРӨНГӨ                                                        | 53,100.00             | 14,685.17               |
| Банкинд байгаа бэлэн мөнгө                                            |                       | 14,685.17               |
| Төсөвт байгууллагын харилцах                                          | 53,100.00             |                         |
| <b>АВЛАГА</b>                                                         | <b>12,762,068.52</b>  | <b>101,109,134.00</b>   |
| Байгууллагаас авах авлага                                             | 9,951,594.52          | 101,014,591.00          |
| Хувь хүмүүсээс авах авлага                                            | 2,810,474.00          | 94,543.00               |
| <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                                                 | <b>68,081,075.99</b>  | <b>48,140,438.65</b>    |
| <b>Хангамжийн материал</b>                                            | <b>68,081,075.99</b>  | <b>48,140,438.65</b>    |
| Бичиг хэргийн материал                                                | 60,144,082.30         | 40,727,938.28           |
| Түлш, шатах тослох материал                                           | 2,367,528.81          | 5,550,894.00            |
| Бусад бараа материал                                                  | 3,329,726.94          | 1,861,606.37            |
| Бусад                                                                 | 2,239,737.94          |                         |
| <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                        | <b>80,896,244.51</b>  | <b>149,264,257.82</b>   |
| <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                                                 | <b>498,412,909.18</b> | <b>1,187,971,380.11</b> |
| <b>Биет хөрөнгө</b>                                                   | <b>492,959,410.38</b> | <b>744,294,365.63</b>   |
| Барилга, байгууламж, орон сууц                                        | 175,147,872.00        | 175,147,872.00          |
| Хуримтлагдсан элэгдэл                                                 | (121,013,162.87)      | (124,043,976.87)        |
| Барилга, байгууламж орон сууц - үлдэгдэл өртөг                        | 54,134,709.13         | 51,103,895.13           |
| Авто-тээврийн хэрэгсэл                                                | 170,795,241.00        | 339,346,525.60          |
| хуримтлагдсан элэгдэл                                                 | (79,414,133.89)       | (144,335,193.39)        |
| Авто-тээврийн хэрэгсэл -Үлдэгдэл өртөг                                | 91,381,107.11         | 195,011,332.21          |
| Машин тоног төхөөрөмж(компьютер)                                      | 446,726,418.35        | 567,202,887.90          |
| Хуримтлагдсан элэгдэл                                                 | (232,419,424.97)      | (262,528,697.41)        |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) - Үлдэгдэл өртөг                     | 214,306,993.38        | 304,674,190.49          |
| Тавилга, аж ахуйн эд хогшил                                           | 156,452,238.00        | 224,160,504.18          |
| Хуримтлагдсан элэгдэл                                                 | (81,031,753.48)       | (88,371,672.62)         |
| Тавилга, аж ахуйн эд хогшил -Үлдэгдэл өртөг                           | 75,420,484.52         | 135,788,831.56          |
| Бусад үндсэн хөрөнгө                                                  | 2,498,435.00          | 2,498,435.00            |
| Хуримтлагдсан элэгдэл                                                 | (1,582,318.76)        | (1,582,318.76)          |
| Бусад үндсэн хөрөнгө -Үлдэгдэл өртөг                                  | 916,116.24            | 916,116.24              |
| Дуусаагүй барилга, байгууламж                                         | 56,800,000.00         | 56,800,000.00           |
| <b>Биет бус хөрөнгө</b>                                               | <b>5,453,498.80</b>   | <b>443,677,014.48</b>   |
| Програм хангамж                                                       | 8,592,599.90          | 505,660,599.90          |
| Хуримтлагдсан элэгдэл                                                 | (3,139,101.10)        | (66,623,585.42)         |
| Програм хангамж - Үлдэгдэл өртөг                                      | 5,453,498.80          | 439,037,014.48          |
| Бусад биет бус хөрөнгө                                                |                       | 4,640,000.00            |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                             | <b>579,309,153.69</b> | <b>1,337,235,637.93</b> |
| <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | <b>6,250,500.00</b>   | <b>20,530,775.59</b>    |
| Бусад өглөг                                                           | 6,250,500.00          | 20,530,775.59           |
| Байгууллагад төлөх өглөг                                              | 6,250,500.00          | 20,530,775.59           |
| <b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>                                          | <b>6,250,500.00</b>   | <b>20,530,775.59</b>    |
| <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | <b>573,058,653.69</b> | <b>1,316,704,862.34</b> |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан | 569,052,417.79        | 569,052,417.79          |
| Хуримтлагдсан үр дүн                                                  | (85,530,879.07)       | 658,115,329.58          |
| Өмнөх үеийн үр дүн                                                    | (100,048,105.18)      | (85,530,879.07)         |
| Тайлант үеийн үр дүн                                                  | 14,517,226.11         | 743,646,208.65          |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 89,537,114.97         | 89,537,114.97           |
| <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>573,058,653.69</b> | <b>1,316,704,862.34</b> |
| <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>                            | <b>579,309,153.69</b> | <b>1,337,235,637.93</b> |

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ                                                                            | ӨМНӨХ ОН                 | ТАЙЛАНТ ОН               |
|-------------------------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                                       | 1,386,946,900.00         | 1,546,418,000.00         |
| <b>Урсгал үйл ажиллагааны санхүүжилт</b>                                            | <b>1,386,946,900.00</b>  | <b>1,546,418,000.00</b>  |
| Германы хамтын ажиллагаа                                                            | 3,533,900.00             | 7,745,455.00             |
| Санхүүгийн хүртээмжийн холбоо ОУБ                                                   |                          | 91,342,875.01            |
| <b>Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг Торгуулийн орлого</b> | <b>201,816,370.00</b>    | <b>1,001,595,203.82</b>  |
| Хөрөнгийн                                                                           | 14,882,160.00            | 848,230,123.82           |
| Торгууль төлбөрийн орлого                                                           | 186,934,210.00           | 153,365,080.00           |
| <b>Данс андуурсан орлого</b>                                                        |                          |                          |
| <b>Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого</b>                             | <b>1,349,472,350.77</b>  | <b>1,313,647,102.16</b>  |
| <b>Үндсэн бус үйл ажиллагааны орлого Байршуулсан хөрөнгийн орлого</b>               | <b>58,187,185,345.02</b> | <b>79,179,933,421.03</b> |
| <b>Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого</b>                                           | <b>95,453,100.00</b>     | <b>223,449,000.00</b>    |
| <b>Тэмдэгтийн хураамжийн орлого</b>                                                 | <b>72,733,700.00</b>     | <b>108,418,000.00</b>    |
| <b>Бусад орлого</b>                                                                 | <b>36,439,999.16</b>     | <b>14,843,677.84</b>     |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                                              | <b>61,333,581,664.95</b> | <b>83,487,392,734.86</b> |
| <b>АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ</b>                                                           | <b>1,333,221,786.72</b>  | <b>1,636,153,939.00</b>  |
| <b>Үндсэн болон нэмэгдэл цалин</b>                                                  | <b>1,176,745,962.00</b>  | <b>1,476,024,239.00</b>  |
| Үндсэн цалин                                                                        | 965,791,051.00           | 1,103,442,359.00         |
| Унаа хоолны хөнгөлөлт                                                               | 76,866,864.00            | 168,113,304.00           |
| Улсын байцаагчийн урамшуулал                                                        | 134,088,047.00           | 204,468,576.00           |
| <b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>                                                  | <b>156,475,824.72</b>    | <b>160,129,700.00</b>    |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл                                                   | 156,475,824.72           | 160,129,700.00           |
| <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                                |                          | 80,590,567,065.36        |
| Бараа үйлчилгээний урсгал зардал                                                    | 802,200,057.75           | 1,148,850,564.33         |
| <b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>                                              | <b>180,030,425.28</b>    | <b>203,771,799.94</b>    |
| Бичиг хэргийн зардал                                                                | 17,570,641.88            | 27,348,820.00            |
| Тээвэр, шатахуун                                                                    | 26,520,000.00            | 25,910,752.69            |
| Шуудан, харилцаа холбоо                                                             | 76,145,075.97            | 68,662,227.25            |
| Дотоод албан томилолт                                                               | 20,208,553.39            | 45,418,273.00            |
| Гадаад албан томилолт                                                               | 39,586,154.04            | 36,431,727.00            |
| <b>Жижиг эд хогшил худалдан авах</b>                                                |                          | <b>15,050,000.00</b>     |
| Жижиг эд хогшил худалдан авах \Багаж хэрэгсэл\                                      |                          | 3,250,000.00             |
| Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\                                             |                          | 6,800,000.00             |
| Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс\                   |                          | 5,000,000.00             |
| Байрны ашиглалтын түрээсийн зардал                                                  | 234,003,595.70           | 194,807,871.00           |
| Төлбөр хураамж, жижиг татварууд                                                     | 20,599,212.00            | 15,103,628.00            |
| Төвлөрсөн арга хэмжээ                                                               |                          | 122,582,868.00           |
| Урсгал засвар                                                                       | 27,293,112.00            | 21,877,800.00            |
| Гадаад зочны зардал                                                                 | 7,911,142.00             | 1,403,200.00             |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                                  | 68,886,601.77            | 119,389,178.39           |
| <b>Бусад зардлын дүн</b>                                                            | <b>59,183,642,594.37</b> | <b>79,441,716,501.03</b> |
| Торгуулийн орлого төвлөрүүлэх                                                       | 189,081,382.00           | 153,365,080.00           |
| Тэмдэгтийн хураамжийн орлого ОН-ийн төсөвт                                          | 72,733,700.00            | 108,418,000.00           |
| ДСБайршуулалт                                                                       | 58,187,185,345.02        | 79,179,933,421.03        |
| Төвлөрүүлэх шилжүүлэг                                                               | 734,642,167.35           |                          |

|                                                    |                          |                          |
|----------------------------------------------------|--------------------------|--------------------------|
| <b>Хөтөлбөр арга хэмжээний зардал</b>              | <b>110,471,507.00</b>    |                          |
| Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод)     | 15,071,507.00            | <b>19,666,794.00</b>     |
| Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт             | 95,400,000.00            | <b>223,449,000.00</b>    |
| <b>Сургалт, хурал, зөвлөгөөний зардал</b>          | <b>48,148,510.00</b>     | <b>33,303,600.00</b>     |
| Гадаад сургалт, семинарт оролцох зардал            |                          |                          |
| Сургалт, семинар зохион байгуулах зардал           | 48,148,510.00            | 33,303,600.00            |
| Сургалт семинарын зардал                           |                          |                          |
| <b>Хөтөлбөр болон төслийн дотоод урсгал зардал</b> | <b>44,892,017.00</b>     | <b>63,699,938.00</b>     |
| <b>Бусад төсөл арга хэмжээ</b>                     | <b>3,533,900.00</b>      | <b>7,745,455.00</b>      |
| <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ</b> |                          |                          |
| <b>ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ</b>                          |                          | <b>517,025,522.06</b>    |
| Төвлөрүүлэх шилжүүлэг                              |                          | 425,629,547.05           |
| Төвлөрүүлэх шилжүүлэг                              |                          | 53,100.00                |
| Татан төвлөрүүлэлт                                 |                          | 91,342,875.01            |
| <b>Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж</b>           | <b>7,828,535.00</b>      | <b>38,009,472.00</b>     |
| Мөнгөн хэлбэрээр                                   |                          |                          |
| Тэтгэвэрт гарахад олгосон тэтгэмж                  |                          | 24,916,200.00            |
| Нэг удаагийн буцалтгүй тусламж                     | 7,828,535.00             | 13,093,272.00            |
| <b>ОУ-ын байгууллагын гишүүний татварт</b>         | <b>48,601,500.00</b>     | <b>68,989,960.00</b>     |
|                                                    |                          |                          |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                 | <b>61,319,064,438.84</b> | <b>82,743,746,526.42</b> |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>                      | <b>14,517,226.11</b>     | <b>743,646,208.44</b>    |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>                 | <b>14,517,226.11</b>     | <b>743,646,208.65</b>    |

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ                                                           | ӨМНӨХ ОН                 | ТАЙЛАНТ ОН               |
|--------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                      | 1,386,946,900.00         | 1,546,418,000.00         |
| Улсын төвлөрсөн төсвөөс                                            |                          |                          |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                  | 1,386,946,900.00         | 1,546,418,000.00         |
| Бусад шатны /Орон нутгийн/ төсвөөс авах санхүүгийн дэмжлэг         | 58,262,039,698.42        | 79,288,351,421.03        |
| Төслийн орлогын санхүүжилтийн дүн                                  | 3,533,900.00             | 99,088,330.01            |
| Германы хамтын ажиллагаа                                           |                          | 7,745,455.00             |
| Санхүүгийн хүртээмжийн холбоо ОУБ                                  |                          | 91,342,875.01            |
| Хөрөнгийн Тэмдэгтийн хураамж                                       | 72,733,700.00            | 108,418,000.00           |
| Төсөвт байгууллагаас Дүрмийн сангийн байршуулалт                   | 58,187,185,345.02        | 79,179,933,421.03        |
| Бусад орлого                                                       | 2,120,653.40             |                          |
| <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                         | <b>1,631,859,660.77</b>  | <b>1,690,461,182.16</b>  |
| Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого                   | 1,349,472,350.77         | 1,313,647,102.16         |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого Торгууль                         | 186,934,210.00           | 153,365,080.00           |
| Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого                                 | 95,453,100.00            | 223,449,000.00           |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>                      | <b>61,284,380,159.19</b> | <b>82,624,318,933.20</b> |
| АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ                                                 | 1,333,221,786.72         | 1,636,153,939.00         |
| Үндсэн болон нэмэгдэл цалин                                        | 1,176,745,962.00         | 1,476,024,239.00         |
| Үндсэн цалин                                                       | 965,791,051.00           | 1,103,442,359.00         |
| Гэрээт ажилчдын цалин                                              |                          |                          |
| Унаа хоолны хөнгөлөлт                                              | 76,866,864.00            | 168,113,304.00           |
| Улсын байцаагчийн урамшуулал                                       | 134,088,047.00           | 204,468,576.00           |
| <b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>                                 | <b>156,475,824.72</b>    | <b>160,129,700.00</b>    |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл                                  | 128,026,224.72           | 130,986,094.60           |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж                                    | 28,449,600.00            | 29,143,605.40            |
| <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                               | <b>59,951,105,272.47</b> | <b>80,988,203,409.03</b> |
| <b>Бараа үйлчилгээний урсгал зардал</b>                            | <b>1,502,104,845.45</b>  | <b>1,546,486,908.00</b>  |
| <b>Тогтмол зардал</b>                                              | <b>234,003,595.70</b>    | <b>194,807,871.00</b>    |
| Байрны түрээс                                                      | 234,003,595.70           | 194,807,871.00           |
| <b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>                             | <b>162,909,927.97</b>    | <b>185,621,737.94</b>    |
| Бичиг хэргийн зардал                                               | 15,352,835.00            | 27,348,820.00            |
| Тээвэр, шатахуун                                                   | 26,520,000.00            | 25,910,752.69            |
| Шуудан, харилцаа холбоо                                            | 76,145,075.97            | 68,662,227.25            |
| Хөтөлбөр болон төслийн дотоод урсгал зардал                        | 44,892,017.00            | 63,699,938.00            |
| <b>Жижиг эд хогшил худалдан авах зардал</b>                        | <b>36,367,029.00</b>     | <b>15,050,000.00</b>     |
| Жижиг эд хогшил худалдан авах \Багаж хэрэгсэл\                     |                          | 6,800,000.00             |
| Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\                            | 36,367,029.00            | 3,250,000.00             |
| Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\                    |                          | 5,000,000.00             |
| <b>Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний бусад зардал</b> | <b>58,449,000,427.02</b> | <b>79,441,716,501.03</b> |
| Торгуулийн орлого улсын төсөвт                                     | 189,081,382.00           | 153,365,080.00           |
| Дүрмийн сангийн байршуулалт                                        | 58,187,185,345.02        | 79,179,933,421.03        |
| Тэмдэгтийн хураамжийн орлого ОН-ийн төсөвт                         | 72,733,700.00            | 108,418,000.00           |
| <b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>                             | <b>130,669,680.43</b>    | <b>139,901,422.00</b>    |
| Төлбөр хураамж, жижиг татварууд                                    | 20,599,212.00            | 15,103,628.00            |
| Урсгал засвар                                                      | 27,293,112.00            | 21,877,800.00            |
| Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод)                     | 15,071,507.00            | 19,666,794.00            |
| Дотоод албан томилолт                                              | 20,208,553.39            | 45,418,273.00            |

|                                                            |                          |                          |
|------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|
| Гадаад албан томилолт                                      | 39,586,154.04            | 36,431,727.00            |
| Гадаад зочны зардал                                        | 7,911,142.00             | 1,403,200.00             |
| <b>Хөтөлбөр арга хэмжээний зардал</b>                      | <b>95,400,000.00</b>     | <b>223,449,000.00</b>    |
| Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт                     | 95,400,000.00            | 223,449,000.00           |
| <b>Сургалт, хурал, зөвлөгөөний зардал</b>                  | <b>48,148,510.00</b>     | <b>33,303,600.00</b>     |
| Сургалт семинарын зардал                                   | 48,148,510.00            | 33,303,600.00            |
| Төвлөрсөн арга хэмжээ                                      |                          | <b>122,582,868.00</b>    |
| <b>Төсвийн хуваарилагдаагүй зардал</b>                     | <b>3,533,900.00</b>      | <b>7,745,455.00</b>      |
| Германы хамтын ажиллагаа                                   | 3,533,900.00             | 7,745,455.00             |
| <b>ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>734,642,167.35</b>    | <b>517,025,522.06</b>    |
| Төвлөрүүлэх шилжүүлэг                                      |                          | 425,629,547.05           |
| Төвлөрүүлэх шилжүүлэг                                      |                          | 53,100.00                |
| Нэмэлт санхүүжилт                                          |                          |                          |
| Татан төвлөрүүлэлт                                         | 734,642,167.35           | 91,342,875.01            |
| <b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</b>                          | <b>7,828,535.00</b>      | <b>38,009,472.00</b>     |
| <b>Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж</b>                     |                          | 24,916,200.00            |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал                            | 7,828,535.00             | 13,093,272.00            |
| <b>Олон улсын гишүүн байгууллагын татварт</b>              | <b>48,601,500.00</b>     | <b>68,989,960.00</b>     |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)</b>             | <b>61,284,327,059.19</b> | <b>82,624,357,348.03</b> |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b> | 53,100.00                | (38,414.83)              |
| <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                           | <b>53,100.00</b>         |                          |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>    |                          | <b>53,100.00</b>         |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>   | 53,100.00                | <b>14,685.17</b>         |

# АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ                                    | ЗАСГИЙН ГАЗРЫН<br>ОРУУЛСАН КАПИТАЛ | ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ<br>ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН |
|---------------------------------------------|------------------------------------|-------------------------------------------|
| 2013 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл          | 569,052,417.79                     | 558,541,427.58                            |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт  |                                    |                                           |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл                  |                                    |                                           |
| Тайлант үеийн үр дүн                        |                                    | 14,517,226.11                             |
|                                             |                                    |                                           |
| <b>2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b> | <b>569,052,417.79</b>              | <b>573,058,653.69</b>                     |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт  |                                    |                                           |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл                  |                                    |                                           |
| Тайлант үеийн үр дүн                        |                                    | 743,646,208.65                            |
| <b>2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b> | <b>569,052,417.79</b>              | <b>1,316,704,862.34</b>                   |

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ                                       | ТӨЛӨВЛӨГӨӨ       | ГҮЙЦЭТГЭЛ        |
|------------------------------------------------|------------------|------------------|
| Нийт зарлагын дүн                              | 2,516,311,500.00 | 2,434,420,869.94 |
| Урсгал зардлын дүн                             | 2,516,311,500.00 | 2,434,420,869.94 |
| Бараа, үйлчилгээний зардал                     | 2,406,130,100.00 | 2,327,421,437.94 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил              | 1,476,089,800.00 | 1,476,024,239.00 |
| Үндсэн цалин                                   | 1,268,387,300.00 | 1,103,442,359.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт                          | 71,970,800.00    | 168,113,304.00   |
| Улсын байцаагчийн урамшуулал                   | 135,731,700.00   | 204,468,576.00   |
| Нийгмийн хамгааллын шимтгэл                    | 160,129,700.00   | 160,129,700.00   |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл              | 131,015,800.00   | 131,015,800.00   |
| Байгууллага төлөх ЭМД-ын хураамж               | 29,113,900.00    | 29,113,900.00    |
| Бараа, үйлчилгээний зардал                     | 769,910,600.00   | 691,267,498.94   |
| Байрны түрээсийн зардал                        | 210,603,200.00   | 194,807,871.00   |
| Тээвэр (шатахуун)                              | 25,177,900.00    | 25,910,752.69    |
| Шуудан холбоо                                  | 70,400,400.00    | 68,662,227.25    |
| Бичиг хэрэг                                    | 26,278,200.00    | 27,348,820.00    |
| Хөтөлбөр, төслийн дотоод урсгал зардал         | 71,800,000.00    | 63,699,938.00    |
| Жижиг эд хогшил худалдан авах (Тавилга)        | 2,880,000.00     | 6,800,000.00     |
| Жижиг эд хогшил худалдан авах (Багаж хэрэгсэл) | 3,250,000.00     | 3,250,000.00     |
| Мэдээлэл технологи (Програм хангамж)           | 5,000,000.00     | 5,000,000.00     |
| Урсгал засвар                                  | 27,681,100.00    | 21,877,800.00    |
| Төлбөр хураамж болон бусад зардал              | 20,000,000.00    | 15,103,628.00    |
| Мэдээлэл, сурталчилгааны зардал                | 24,630,400.00    | 19,666,794.00    |
| Төвлөрсөн арга хэмжээ                          | 153,872,900.00   | 122,582,868.00   |
| Сургалт семинар зохион байгуулах зардал        | 44,400,000.00    | 33,303,600.00    |
| Дотоод албан томилолт                          | 47,502,500.00    | 45,418,273.00    |
| Гадаад томилолт, арга хэмжээ                   | 35,048,700.00    | 36,431,727.00    |
| Гадаад зочны зардал                            | 1,385,300.00     | 1,403,200.00     |
| Татаас ба урсгал шилжүүлэг                     | 110,181,400.00   | 106,999,432.00   |
| Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж                | 24,916,200.00    | 24,916,200.00    |
| Нэг удаагийн буцалтгүй тусламж                 | 16,275,000.00    | 13,093,272.00    |
| Олон улсын байгууллагын гишүүний татвар        | 68,990,200.00    | 68,989,960.00    |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                 | 2,516,311,500.00 | 2,434,435,555.11 |
| Үндсэн үйл ажиллагааны                         | 800,000,000.00   | 1,313,647,102.16 |
| Төсвөөс санхүүжих                              | 1,716,311,500.00 | 1,120,788,452.95 |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл                | 53,100.00        |                  |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл               |                  | 14,685.17        |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО                               | 1                |                  |
| АЖИЛЛАГСАД БҮГД                                | 134              |                  |
| Удирдах ажилтан                                | 20               |                  |
| Гүйцэтгэх ажилтан                              | 104              |                  |
| Үйлчлэх ажилтан                                | 10               |                  |